



# ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК



Даланзадгад хот

2017 он



## ХҮН АМ



Монгол Улсын нийт хүн ам 2016 онд **3,119,935** болж, өмнөх оныхоос **62,157** буюу **2.03** хувиар өслөө. Улсын хэмжээнд 2016 онд **79,920** хүүхэд мэндэлсэн. Нийт хүн амын 64,67 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын **30.05** хувь буюу **937,518** нь 0-14 насны хүүхэд, **63.82** хувь буюу **1,991,183** нь 15-59 насны хүмүүс, **6.13** хувь буюу **191,234** нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан байна.

ХҮН АМЫН ТОО	2014 он	2015 он	2016 он
Улсын дүн	2995949	3057778	3119935
Өмнөговь	59665	61540	63661

Өмнөговь аймаг 2016 оны эцэст 63661 хүн амтай болж 2015 оны эцсийн хүн амын мэдээнээс 3.4 хувиар буюу 2121 хүнээр өслөө. Нийт хүн амын 50.2 хувь буюу 31960 эрэгтэйчүүд, 49.8 хувь буюу 31701 эмэгтэйчүүд эзлэж байна. Нийт хүн амын 39 хувийг Даланзадгад сумын төв, 21.4 хувийг Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын төвд суурьшиж байна. Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилвал 32 хувийг 0-15 насны хүүхэд, 62 хувийг 16-59 насны, 6 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна. Өрхийн тоо 20669 болж өмнөх оноос 675 өрхөөр буюу 3.4 хувиар өссөн дүнтэй байна.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014 он	2015 он	2016 он
Бүтэн өнчин хүүхдийн тоо	43	51	45
Хагас өнчин хүүхдийн тоо	553	563	588
2 ихэр хүүхдийн тоо	256	288	304
3 ихэр хүүхдийн тоо	6	6	9





## ГЭМТ ХЭРЭГ

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ	2014он	2015он	2016он
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	27318	27757	27167
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2143	2010	1783
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	8697	8468	8691
Хүнийг санаатай алах	211	204	174
Бусдыг болгоомжгүй алах	27	32	24
Амиа хорлосон	43	24	26
Золгүй явдлаас нас барсан	245	120	180
Бусдын бие махбодид гэмтэл учруулах	8132	8064	8248
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	249	269	268
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	118	106	91
Албан тушаалын гэмт хэрэг	135	128	111
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	11	12	10
Малын хулгайн гэмт хэрэг	1434	1180	805
Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг	1076	1356	1449
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	49	57	44
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	397	383	384
Хүчин	300	279	290
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	144	141	116
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	12551	13445	13336
Хулгай	8424	9169	9065
Булаалт	245	216	176
Дээрэм	686	537	474
Залилан	1843	2067	2165
Завших, үрэгдүүлэх	297	333	322
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	426	520	227
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1750	1630	1479
Танхайрах гэмт хэрэг	1681	1582	1449
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	303	341	416
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	287	228	165




Монгол Улсын хэмжээнд сэжигтэн яллагдагчын тоо 2016 онд **23805** болж, өмнөх оныхоос **1052** буюу **4,4** хувиар буурсан байна.

### ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭДИЙН ТОО


Насны бүлэг	2014он	2015он	2016он
7 хүртэлх	205	201	208
8-13	389	396	375
14-17	982	880	757
18-24	4297	3854	3693
25-29	5008	5225	5061
30-34	4115	4449	4552
35-39	3533	3668	3660
40-44	2896	3000	3048
45-49	2236	2246	2366
50-54	1726	1760	1748
55-59	998	1156	1108
60-64	500	532	546
65-69	285	268	268
70 ба түүнээс дээш	305	313	299
Хохирогч иргэд	27475	27948	27689

2016 оны байдлаар 18-аас 39 насныхан хамгийн ихээр хохирсон байна. 2016 онд 18-39 насныхан **16966** буюу **61,27** хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2015 онтой харьцуулахад 2016 онд **259** буюу **0,9** хувиар буурсан байна.



### ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ


Төвийн бүсийн аймгууд	2014 он	2015 он	2016 он
Төв	11	12	15
Говьсүмбэр	3	4	7
Сэлэнгэ	17	16	20
Дорноговь	11	8	10
Дархан-Уул	25	14	8
Өмнөговь	7	9	13
Дундговь	8	2	1
Төвийн бүс	82	65	74
Бүгд	397	383	384





## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд 2016 онд 27167 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар буурч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1449 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 93 хэргээр буюу 6.9 хувиар, бүх хэрэгт эзлэх хувийн жин 5.3 хувь болж, 0.4 нэгжээр тус тус өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 83.0 хувийг хөнгөн, 11.4 хувийг хүндэвтэр, 3.5 хувийг хүнд, 2.1 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж, 57.8 хувь нь Улаанбаатар хотод, 42.2 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.




- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэгдсэн хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл:

2016 он	Бүртгэгдсэн хэргийн тоо	Эзлэх хувь
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	1373	94.76%
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	38	2.62%
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг	33	2.28%
Өмчлөх эрхийн эсрэг	4	0.28%
Шүүн таслах ажиллагааны эсрэг	1	0.07%

- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэгдсэн хэргийг Эрүүгийн зүйлээр авч үзвэл:

2016 он	Бүртгэгдсэн хэргийн тоо	Эзлэх хувь
Бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг	1356	93.58%
Танхайрах хэрэг	38	2.62%
Хүчиндэх хэрэг	26	1.79%
Хүнийг санаатай алах	16	1.10%
Бусад төрлийн хэрэг	13	0.90%

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 595 буюу 41.1 хувь нь согтуугаар, 91 буюу 6.3 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.



2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт 27689 иргэн өртөж хохирсноос гэр бүлийн хүчирхийлэлд 1357 иргэн өртөж хохирсоны 90.7 хувь нь эмэгтэй хүн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 830, хамтран амьдрагч 229, нөхөр 74, төрсөн хүүхэд 42, дагавар хүүхэд 31, хадам эцэг, эх 20, төрсөн эцэг, эх 15, төрсөн дүү 13, төрсөн ах, эгч 13, өвөө 1, бусад 89 хүн байсан Мөн 18 хүн нас барж, 1217 хүн гэмтэж, иргэдэд 851.1 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирчээ.



Мөн хугацаанд улсын хэмжээнд бүртгэгдсэн бүх гэмт хэрэгт 23805 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны 1455 буюу 6.1 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсний учир холбогдон шалгагдаж тэдний 39.5 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдэн бүртгэгдсэн байна.



## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Сумдууд	Бүртгэгдсэн гэмт хэргүүд			Хүчин			Танхай		
	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он
Баяндалай	4	10	7						
Баян-Овоо	11	6	8						
Булган	12	13	7			1		1	1
Гурвантэс	38	61	49			2	5	6	
Мандал-Овоо	10	8	6				1	1	
Манлай	3	6	8						
Номгон	4	8	10	1					
Ноён	1	1	4						
Сэврэй	5	6	2						
ханбогд	78	54	51	1	1	1			1
Ханхонгор	8	18	12						
Хүрмэн	9	8	13						
Цогт-Овоо	8	6	11	1					1
Цогтцэций	78	68	66	1	1	2	1		
Даланзадгад	160	123	155	2	3	2	3	2	4
Дүн	429	396	409	6	5	11	10	10	7

Сумдууд	ИЭЧЭМЭ			Хулгай			Бусдыг залилах			Бусад хэрэг		
	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он
Баяндалай	2	4	1	1	5	2				1	1	4
Баян-Овоо	3	2	2	8	4	6						
Булган	4	3	2	6	4	1		1		2	4	2
Гурвантэс	13	19	24	10	9	9		4		110	23	14
Мандал-Овоо	4	1	5	4	5	1				1	1	
Манлай		2	4	1	4	4				2		
Номгон	2	5	3		3	2				1		5
Ноён	1		1			1			1		1	1
Сэврэй			1	2	3					3	3	1
ханбогд	22	15	17	35	11	17	4			16	27	15
Ханхонгор	1	7	6	6	10	3				1	1	3
Хүрмэн	3	6	10	5		2				1	2	1
Цогт-Овоо	3	3	7	4	2	3					1	
Цогтцэций	37	25	28	29	23	14	1	5	2	9	14	20
Даланзадгад	56	58	65	93	34	50	2	4	11	4	22	20
Дүн	151	150	176	204	117	115	7	14	14	51	100	86



2016 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээнд гэмт хэрэг 409 гарсан нь өмнөх оны мөн үеэс 13 хэргээр буюу 3.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Оны эхний 12 сард гарсан нийт гэмт хэргийн илрүүлэлт 71.7 хувьтай байгаа нь улсын дунджаас 7.7 хувиар өндөр үзүүлэлттэй байна.



Оны эхний 12 сарын байдлаар захиргааны зөрчлийн мэдээллээр саатуулагдсан хүний тоо 670 байгаа нь өмнөх оны мөн үеэс 542 хүнээр буюу 44.7 хувиар, баривчлагдсан хүний тоо 49 байгаа нь өмнөх оны мөн үеэс 181 хүнээр буюу 78.7 хувиар тус тус буурч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан жолооч 676 байгаа нь өмнөх оны мөн үеэс 233 хүнээр буюу 52.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


### ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭДИЙН ТОО

	2014 он	2015 он	2016 он
7 хүртэлх	5	10	7
8-13	8	9	5
14-17	10	11	19
18-24	62	47	44
25-29	86	73	77
30-34	83	81	87
35-39	67	60	55
40-44	54	59	41
45-49	29	34	34
50-54	22	23	37
55-59	15	11	11
60-64	6	12	6
65-69	6	4	3
70 ба түүнээс дээш	1	3	3
Хохирогч иргэд	454	437	429



### ОНЦГОЙ БА ХҮНД НӨХЦЛӨӨР БҮРТГЭГДСЭН ХҮҮХДИЙН ТОО

	2014 он	2015 он	2016 он
Амиа хорлох оролдлого хийсэн хүүхдийн тоо	5	2	5
Зам тээврийн болон ахуйн осолд өртсөн хүүхдийн тоо	7	6	6
Садар самуун хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо	3	5	6
Ахуйн осолд өртсөн хүүхдийн тоо	4	0	2





## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

	2016	2017
<b>Улсын дүн</b>	<b>956</b>	<b>870</b>
<b>Гэр бүлийн хүчирхийлэлд автсан (Өмнөговь аймаг)</b>	18	14
<b>Хэлбэр</b>		
Биемахбодийн	10	11
Сэтгэл санааны	1	1
<b>Хугацаа</b>		
0-1 жил	12	5
1-3 жил	4	5
5-8 жил	1	-
8-аас дээш жил	1	-
<b>Давтамж</b>		
Жилд 1-2 удаа	17	6
Улиралд 1-2 удаа	-	3
Сард 1-2 удаа	-	1
14 хоног тутам	1	-
<b>Хохирогч</b>		
Эхнэр	14	8
Хамтран амьдрагч	2	3
Төрсөн эцэг, эх	1	-
Дагавар хүүхэд	-	1
Бусад	1	2

Өмнөговь аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар гэр бүлийн хүчирхийлэлд автсан 18 иргэн байгаагаас 10 иргэн нь биемахбодын буюу нөхөр, хамтран амьдрагчдаа зодуулсан байна. Садар самуун хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 6 байна. Энэ нь өмнөх үеийнхээс өссөн үзүүлэлттэй буюу цаашид гэр бүл, бага насны хүүхдийн хүчирхийлэл өсөх хандлагатай байна гэж судлаачид үзэж байна.

*Үнэн зөв бүртгэл мэдээлэл*

*Үеийн үед түүх болж үлдэнэ*

*Үнэнд тулгуурласан бодлого*

*Үйлсийн тэнгэрт нар болж мандана*

Харилцах утас: 70533061, 70533439

**E-mail хаяг** [umnugovi@nso.com](mailto:umnugovi@nso.com)

2017 оны 10 сарын 23